



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2016.01.12 № 01/269
танай _____-ны № _____-т

Үнэлгээний дүн хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар баталсан “Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлэх аргачлал”-ын дагуу нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгарсан “Эм Ди Эс энд Хаан Лекс” ХХН, “Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо” ТББ, “Хөгжлийн санаачилга бодлого судлалын төв” ТББ, “Эс Ай Си Эй” ХХК-ын төлөөлөл бүхий шинжээчдийн 4 баг төрийн байгууллагуудын 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ хийж, дүнг олон нийтэд зарлаад байна. Энэхүү үнэлгээ нь 3 дахь удаагаа хийгдэж байгаа бөгөөд Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын “Найм”-ын 61-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болдог билээ.

Энэ удаагийн үнэлгээнд Улсын Их Хурлаас байгуулагддаг 7 байгууллага, 15 яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч 28 агентлаг, аймаг, нийслэл 22, нийслэлийн 9 дүүрэг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 39 хуулийн этгээд, нийт 122 байгууллага хамрагдлаа. Үнэлгээ нь авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг 0-70 оноо, авлигатай тэмцэх санал, санаачилгыг 0-30 оноо, нийт 100 оноогоор үнэлдэг бөгөөд “Монголын төмөр зам” ТӨХК 86.8 оноо авч өмнөх оны 58 оноог 28.8 оноогоор ахиулсан байна.

Шинжээчид үнэлгээний улсын дундаж оноо жил тутам нэмэгдэж байгааг эерэг үр дүн гэж үзсэн байх ба энэ үйл явцыг Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, түүний удирдлагаас анхаарах болсон, мөн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ын зүгээс гаргаж буй хүчин чармайлтын үр дүнтэй холбон тайлбарлажээ.

Шинжээчдийн баг нь дээрх үнэлгээг хийхдээ төрийн байгууллагын цахим хуудас дахь мэдээлэл, тухайн байгууллагаас ирүүлсэн тайлан, нотлох баримтад тулгуурласан бөгөөд “Монголын төмөр зам” ТӨХК аргачлалд тусгасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллахад дараах нөхцөл байдлууд сөргөөр нөлөөлжээ:

000997

1/ дараа жилийн төсвийн төсөл хагас жилийн санхүүгийн тайлан аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл цахим хуудсанд байхгүй, тайланд дурдаагүй;

2/ төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, хянан шалгах зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс, урамшууллын хэмжээг ил тод болгох арга хэмжээ аваагүй, энэ талаар тайланд дурдаагүй;

3/ авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналын талаар тайланд дурдаагүй,


4/ авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх талаарх мэдээлэл тайланд тусгагдаагүй зэрэг болно.

Цаашид 2016 оны "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулахдаа үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн дээрх асуудлуудад анхаарлаа хандуулж зохион байгуулалтын арга хэмжээ авахыг зөвлөхийн зэрэгцээ уг төлөвлөгөөний төслөө 2016 оны 01 дүгээр сарын 30-ны дотор ирүүлэхийг хүсье.

Дээрх чиглэлээр тус газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс арга зүйн зөвлөгөөгөөр хангаж хамтран ажиллах боломжтой болохыг үүгээр мэдэгдэж байна.

Жич: Төрийн байгууллагуудын 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн "Шинжээчдийн баг"-ийн тайланг Авлигатай тэмцэх газрын www.iaac.mn цахим хуудсанд байршуулсан болно.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ